

БАТЛАВ.

ЦЭНГЭГ УСНҮҮН НӨӨЦ БАЙГАЛЬ ХАМГААЛАХ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН АЛБАН ХУРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



У.ДАВААЖАВ

“СУРЧ, ХӨГЖИХ БОЛОМЖ БА ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ”

ВИДЕО БУТЭЭХ УРАЛДААН

№ 2021/05

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Дэлхий нийгээрээ Ковид 19 цар тахалтай дасан зохицон амьдрахын тулд хүн төрөлхтөн технологийн дэвшлүүдийг өдөр тутмын амьдралдаа өргөн хэрэглэж, техник технологийн дэвшилттэй хөл нийлүүлэн улс орнуудад онлайн худалдаа, дижитал төлбөр тооцоо, теле эрүүл мэнд, дижитал энтертайнмент, зайнаас ажиллах, онлайн боловсрол зэрэг чиглэлүүд дижитал шилжилт рүү эрчимтэй шилжиж байна.

Монгол Улсын хүн амын ихэнх хувь буюу 47,2 хувийг 15-40 насны залуучууд эзэлдэг. Залуучуудын боловсрол эзэмших хувь өсөж байгаа бөгөөд тэдэнд суралцахад тулгарч буй бэрхшээл сорилтыг даван туулж дижиталын шилжилтийн энэ үед хэзээ ч, хаана ч, хэнд ч өөрийн хүссэн чадварт суралцах, цаашлаад диплом, сертификаттай төгсөх сургуульд суралцаж хөгжих боломж ч бий. Иймд их дээд сургуулийн оюутан, залуусын дунд энэ цаг үед сорилтыг боломж болгоход чиглэсэн шинэ санал санаачлага, шийдлийг харуулсан “Сурч, хөгжих боломж ба дижитал шилжилт” видео бүтээх уралдааныг зарлаж байна.

ХОЁР. ЗОРИЛГО

Видео бүтээлээр дамжуулан хүүхэд залууст мэдээллийн технологийн дэвшилтэт технологид тулгуурлан өөрийгөө хөгжүүлэх, харилцан суралцах боломжийн талаар бусадтай үзэл бодлоо хуваалцах, идэвх оролцоог дэмжих, олон нийтийгuriалах, сэдэлжүүлэхдэд чиглэгдэнэ.

ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ

Монгол улсын хэмжээнд 19-22 насны их, дээд сургуулийн оюутнуудын оролцох боломжтой

БАТЛАВ.

“БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭДЭЭЛЭЛ
ДОЛЖИН БАЙГАЛЬ ОРЧНЫ
СУРГАЛТЫН ТӨВ НҮТЭВ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



ЭШИНЭЦЦЭГ

“СУРЧ, ХӨГЖИХ БОЛОМЖ БА ДИЖИТАЛ ШИЛЖИЛТ”

ВИДЕО БУТЭЭХ УРАЛДААН

№ 2021/05

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Дэлхий нийгээрээ Ковид 19 цар тахалтай дасан зохицон амьдрахын тулд хүн төрөлхтөн технологийн дэвшлүүдийг өдөр тутмын амьдралдаа өргөн хэрэглэж, техник технологийн дэвшилттэй хөл нийлүүлэн улс орнуудад онлайн худалдаа, дижитал төлбөр тооцоо, теле эрүүл мэнд, дижитал энтертайнмент, зайнаас ажиллах, онлайн боловсрол зэрэг чиглэлүүд дижитал шилжилт рүү эрчимтэй шилжиж байна.

Монгол Улсын хүн амын ихэнх хувь буюу 47,2 хувийг 15-40 насны залуучууд эзэлдэг. Залуучуудын боловсрол эзэмших хувь өсөж байгаа бөгөөд тэдэнд суралцахад тулгарч буй бэрхшээл сорилтыг даван туулж дижиталын шилжилтийн энэ үед хэзээ ч, хаана ч, хэнд ч өөрийн хүссэн чадварт суралцах, цаашлаад диплом, сертификаттай төгсөх сургуульд суралцаж хөгжих боломж ч бий. Иймд их дээд сургуулийн оюутан, залуусын дунд энэ цаг үед сорилтыг боломж болгоход чиглэсэн шинэ санал санаачлага, шийдлийг харуулсан “Сурч, хөгжих боломж ба дижитал шилжилт” видео бүтээх уралдааныг зарлаж байна.

ХОЁР. ЗОРИЛГО

Видео бүтээлээр дамжуулан хүүхэд залууст мэдээллийн технологийн дэвшилтэт технологид тулгуурлан өөрийгөө хөгжүүлэх, харилцан суралцах боломжийн талаар бусадтай үзэл бодлоо хуваалцах, идэвх оролцоог дэмжих, олон нийтийгuriалах, сэдэлжүүлэхдэд чиглэгдэнэ.

ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ

Монгол улсын хэмжээнд 19-22 насны их, дээд сургуулийн оюутнуудын оролцох боломжтой

ДӨРӨВ. БҮТЭЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Ерөнхий шаардлага	1. Видеоны бүтээх хугацаа нь 3 минутаас хэтрэхгүй байна;
	2. Бүтээсэн видеондоо 140 тэмдэгтэд багтаан нэр өгөх
	3. Видеог MP4 форматаар ирүүлэх
	4. Бүтээл нь англи хэл, эсвэл эх хэл дээрээ бол англи хадмал орчуулгатай байх;
	5. Бүтцийн хувьд танилцуулга, дүгнэлт хэсэгтэй байх ба баримтат кино эсвэл сурвалжлага / ярилцлагын хэв маягийг ашиглаж, хэн, юуг, хаана, хэзээ, яагаад, яаж гэсэн асуултанд хариулагдахаар бүтэцтэй байна.
	6. Видеоны төгсгөл хэсэгт ашигласан зураг, видео, ая зэргийн эх сурвалжийг оруулах;
	7. Дууны болон бичлэгийн өндөр чанар бүхий дүрс бичлэгийг хүлээн авах болно. Дүрс бичлэг хамгийн багадаа 720p нягтралтай байх;
	8. Уралдаанд оролцогчид нь овог нэр, нас, хүйс, регистрийн дугаар, аймаг/хот/, сум, холбоо барих утасны дугаар, имэйл хаягийг видеотойгоо хамт ирүүлэх
	9. Уралдаанд ирүүлсэн бүтээлийг зохион байгуулагчдын сан хөмрөгт зохиогчийн эрхтэйгээр үлдэнэ. Мөн оролцогчдын бүтээлийг сонин хэвлэл, цахим сүлжээнд нийтлэх, сурталчилгааны ажилд ашиглах эрхийг уралдаан зохион байгуулагч байгууллагуудад зөвшөөрнө.
	10. Уралдаанд багаараа оролцох боломжтой.
Агуулгын шаардлага	1. Сэдвийн нэр, агуулгад нийцсэн байх;
	2. Видеоны 70%-иас доошгүй хувийг өөрсдийн авсан дүрс, бичлэг, аудио бичлэгээс бүрдэх бөгөөд нэмэлт зураг, видео ашигласан бол эх сурвалжийг дурьдах; /Зохиогчийн эрхээр хамгаалагдсан ая, видеог ашиглахгүй байх/
	3. Бүтээлч хандлага, үндэслэлтэй тоо баримт, жишээнд тулгуурласан байх;
	4. Өөрийн байр сууриа тодорхой, ойлгомжтой илэрхийлсэн байх;
	5. Асуудалд тэнцвэртэй бодитой хандсан байх;
	6. Дэвшиүүлсэн асуудлыг тал бүрээс нь авч үзсэн байх

	7. Видео нь баримт судалгаанд тулгуурласан, тэнцвэртэй, олны анхаарлыг татаж, нийгмийн сэтгэлзүйд хүрэхүйц, мэдээллийн эх сурвалжаа ил тод дурдсан, асуудлыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлж санал болгосон байвал зохино.
Түгээсэн байдал	1. Видео бүтээлээ өөрийн хувийн цахим сүлжээгээр олон нийтэд түгээсэн байх бөгөөд олон нийтэд түгээснийг нотлох баримтыг видео бүтээлийн хамт илгээнэ.

ТАВ. УРАЛДААНЫГ ДҮГНЭХ, ШАЛГАРУУЛАХ

Уралдааны бүтээлийг 2021 оны 04 дүгээр сарын 09-ний 17:00 цаг хүртэл yremongolia@gmail.com хаягаар хүлээн авна. Видеог ютуб сувагт байршуулж линкийг явуулсан байна.

Уралдаанд ирүүлсэн бүтээлийн агуулгын болон хэлбэрийн шаардлага хангасан эсэхийг тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу уралдаан зохион байгуулах ажлын хэсэг дүгнэж, шалгаруулах бөгөөд уралдаан 2 үе шаттай зохион байгуулагдана. Үүнд:

I шат - Оролцогчдын бүтээлийг 2021 оны 04 дүгээр сарын 10-наас 2021 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл цахим сүлжээнд байршуулж цахим хандалт болон шүүгчдийн саналыг үндэслэн эхний 10 бүтээлийг шалгаруулна.

II шат- Мэргэжлийн контент бүтээгч болон зохион байгуулагчдын төлөөллийг багтаасан шүүгчдийн бүрэлдэхүүн 2021 оны 04 дүгээр сарын 16-ны дотор эцсийн шалгаруулалтыг хийнэ.

- Шүүгчид ирүүлсэн бүтээлийн утга санаа, уран сэтгэмж, өгүүлэлмж, тайлбар, чанар, бүтээлийн агуулга ба нэр, тэдгээрийн шүтэлцээ зэргийг үндэслэн доорх байдлаар 0-5 оноогоор дүгнэнэ.
- Үүнд:

- 5 оноо = Онц сайн
- 4 оноо = Mash сайн
- 3 оноо = Сайн
- 2 оноо = Дунд зэрэг
- 1 оноо = Шаардлага хангасан
- 0 оноо = Шаардлага хангаагүй

Уралдаанд бүтээлээ ирүүлсэн оролцогчид шүүгч тус бүрээс ямар ч үнэлгээ авах магадлалтай бөгөөд шалгуур үзүүлэлтүүдийг хангасан оролцогч байр эзэлнэ.

- ❖ Тэргүүн байранд шалгарсан видео бүтээлийг Дэлхийн байгаль орчны боловсролын сан (FEE)-ийн “Байгаль орчны залуу сурвалжлагч” олон улсын уралдаанд оролцуулна.

ЗУРГАА. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

1-р Байр - 1 (500,000) таван зуун мянган төгрөг, өргөмжлөл

2-р байр - 1 (300,000) гурван зуун мянган төгрөг, өргөмжлөл

3-р байр – 1 (200,000) хоёр зуун мянган төгрөг, өргөмжлөл

Тусгай байр – 1 (100,000) зуун мянган төгрөг, өргөмжлөл

ДОЛОО, ХҮРЭХ ҮР ДҮН

- Суралцах, хөгжих боломж хүн бүрт нээлттэй гэдгийг ойлгуулах, сурталчлан таниулах;
- Орчин үеийн дэвшилтэт техник технологийг ашиглан сурч хөгжих шинэ хандлагыг оюутан залууст сурталчлах, тэднийг сэдэлжүүлэх,
- Оюутан, залуусын авьяас чадвар, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх,

НАЙМ. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

- Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв УТҮГ
- Байгаль орчны боловсрол, мэдээллийн төв ТББ

ЁС. ХОЛБОО БАРИХ

Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, Зайсан 9, Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв. Утас: 99153165, 99085775, 92050506